



ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ᠳᠣᠷᠨᠣᠭᠣᠪᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠨᠢᠶᠢᠭᠢᠮ, ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠭᠢᠨ
ᠲᠠᠨᠢᠯᠴᠠᠭᠤᠯᠠ

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2019/08



pdfMachine

Is a pdf writer that produces quality PDF files with ease!

Produce quality PDF files in seconds and preserve the integrity of your original documents. Compatible across nearly all Windows platforms, if you can print from a windows application you can use pdfMachine.

Get yours now!

ᠮᠠᠮᠠᠮᠠ 1212.MN

ГАРЧИГ

Товч танилцуулга.....	1-14
Нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	15
Нэг. Эрүүл мэнд.....	16-17
Хоёр. Хөдөлмөр эрхлэлт	18-20
Гурав. Нийгмийн даатгал, халамж.....	21-24
Дөрөв. Гэмт хэрэг.....	25-26
Тав. Мөнгө,зээл	27
Зургаа. Төсөв, санхүү	28-29
Долоо. Үнэ.....	30-33
Найм. Хөдөө аж ахуй	34-36
Ес. Аж үйлдвэр.....	37-41
Арав. Байгаль орчин	42

pdfMachine

Is a pdf writer that produces quality PDF files with ease!

Produce quality PDF files in seconds and preserve the integrity of your original documents. Compatible across nearly all Windows platforms, if you can print from a windows application you can use pdfMachine.

Get yours now!

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2019 оны 08 дугаар сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт




1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2019 оны 08 сард 847 эх амаржиж, 850 хүүхэд шинээр мэндэлж, 254 хүн нас барсан байна. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 52(5.8%)-оор, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 52(5.8%)-оор, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 10(3.8%)-аар тус тус буурчээ.

Хүн амын цэвэр өсөлт 596 болж 2018 оны мөн үеийнхээс 42(6.6%)-оор буурсан байна. 1000 хүнд ногдох төрөлт 12.3, нас баралт 3.7 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 1.0 пунктээр, нас баралт 0.2 тус тус буурсан байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2016-2019 оны 08 сард



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд нялхсын эндэгдэл 4 байна.



1.2 Эрүүл мэнд


2019 оны 08 сарын байдлаар 261.6 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 12.0 хувиар өсч, 7.3 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар, 11.3 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 0.9 хувиар тус тус буурсан байна.

2019 оны 08 сард 1250 эх жирэмсний хяналтанд орсны 88.2 хувь буюу 1102 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.2 пунктээр өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага 11.7 мянган удаа гарсны 1.9 мянга буюу 16.2 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар, алсын дуудлага өмнөх оны мөн үеэс 5.0 хувиар буурсан байна.

Он гарсаар ослын улмаас 2149 хүн бэртэж, 53 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 28(1.3%)-аар буурч, нас барсан хүний тоо 15(22.1%)-өөр тус тус буурчээ.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2019 оны 08 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд хавдар 26.0 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 24.8 хувь, осол гэмтэл, хордлого гадны шалтгаант үхэл 20.9 хувь, бусад төрлийн өвчин 14.6 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 7.5 хувь, хоол шингээх эрхтний өвчин 6.3 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 692 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 208-аар буюу 43.0 хувиар өсчээ. Халдварт өвчний тохиолдол өсөхөд трихоминиаз 91.8 хувь, бусад төрлийн өвчин 73.4 хувь, тэмбүү 68.0 хувь, заг хүйтэн 46.9 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.




1.4 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2019 оны 08 сарын эцэст 588 болсны 585(99.5%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 3(0.5%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 146(19.9%) хүнээр, өмнөх сараас 33(5.3%) хүнээр тус тус буурчээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 420(71.4%) нь бүрэн дунд, 69(11.7%) нь дээд, 37(6.3%) нь бүрэн бус дунд, 21(3.6%) нь техник болон мэргэжлийн, 18(3.1%) нь тусгай дунд, 17(2.9%) нь боловсролгүй, 3(0.5%) нь магистр, 3(0.5%) нь бага боловсролтой иргэд эзэлж байна.


Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2019 оны 08 сарын эцэст



Хөдөлмөрийн хэлтэст 2019 оны 08 сарын эцэст 29 иргэн шинэ ажлын байранд орж, бүртгэлтэй байсан 314 иргэн ажилд зуучлагдан орж, 48 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.

Хөдөлмөрийн хэлтэст ирсэн 313 ажлын байрны 111(35.5%) нь энгийн ажил, 38(12.1%) нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 37 (11.8%) нь мэргэжилтэн, 48(15.3%) нь техникч болон туслах / дэд мэргэжилтэн, 13(4.2%) нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 20(6.4%) нь контор үйлчилгээний ажилтан, 21(6.7%) нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, 25(8.0%) бусад салбарын ажлын байрны захиалга байна.

Зураг. Бүртгэлгүй ажилгүй иргэд сумаар



1.5 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн

pdfMachine

Is a pdf writer that produces quality PDF files with ease!


Produce quality PDF files in seconds and preserve the integrity of your original documents. Compatible across nearly all Windows platforms, if you can print from a windows application you can use pdfMachine.

Get yours now!




(30.1%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2019 оны 8 сард өмнөх оны мөн үеэс 6352.6 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 4062.2 (30.6%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгал 974.4 (27.7%), ҮОМШӨ-ний даатгал 670.9 (30.5%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 460.4 (30.6%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгал 184.7 (30.3%) сая төгрөгөөр өссөн байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2019 оны 08 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 33449.2 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 4032.4 (13.7%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 24789.7 (74.1%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 4017.8 (12.0%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 2014.1 (6.0%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 1930.0 (5.8%) сая.төг, ажилгүйдлийн даатгалын сангаас 697.6 (2.1%) сая төгрөгийг зарцуулжээ.


Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төг




Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2019 оны 08 сард нийгмийн халамжийн сангаас 23425 иргэнд 5578.6 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 919(4.1%)-аар, олгосон тэтгэвэр тэтгэмж 199.8(3.7%) сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2019 оны 08 сард 1374 хүн хамрагдсан нь өмнөх оноос 21(1.6%)-ээр, олгосон тэтгэвэрийн хэмжээ 189.7(12.6%) сая төгрөгөөр тус тус нэмэгджээ. Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжийг 1046 иргэнд 548.9 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 936 иргэнд 384.5 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 8729 иргэнийг хамруулж, 643.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Бусад төрлийн халамжийн үйлчилгээнд 11340 иргэн хамрагдаж, 2300.5 сая төгрөгийг олгожээ.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /сая. төг/






1.6 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2019 оны 08 дугаар сарын байдлаар 392 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 152 хүн гэмтэж, 19 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 39(11.0%)-өөр, гэмтсэн хүний тоо 71(87.7%) -ээр, нас барсан хүний тоо 4(26.7%)-өөр нэмэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг 39(11.0%)-өөр, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргүүд 2.2 дахин өсч, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 7(58.3%)-оор, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 5(62.5%)-аар, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 14(87.5%)өөр тус тус буурчээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар




Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 38.0 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 30.9 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 8.4 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 5.6 хувийг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 5.6 хувийг улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг, 2.8 хувийг хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, 8.7 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 99 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 58(2.4 дахин)-иар нэмэгдсэн байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Даланжаргалан, Иххэт, Эрдэнэ, Сайншанд, Замын-Үүд сумдад нэмэгдэж, Дэлгэрэх, Сайхандулаан, Хатанбулаг сумдад өмнө онтой адил, бусад сумдад гэмт хэргийн тоо буурсан байна.




Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 2848.4 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2206.9 (3.4 дахин) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Учирсан хохирлын 708.6 (24.9%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 127(32.4%) нь гэр орон сууцандаа, 99 (25.3%) нь согтуугаар, 42(10.7%) нь гудамж олон нийтийн газарт, 31(7.9%) бүлэглэн, 58(14.8%) хувийг эмэгтэй хүн, хүүхэд оролцон, 115 (29.3%) нь шөнийн цагаар /22-06 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 1042 хүн саатуулагдаж, 177 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 2019 оны 0 сард




Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




2.1 Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын зээлдэгчийн тоо 34.3 мянга болж өмнөх оноос 4.4(14.7%) мянган хүнээр нэмэгдэж, нийт хадгаламж эзэмшигчийн тоо 72.4 мянга болж өмнөх оны мөн үеээс 1.4 хувиар буурсан байна.

Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2018-2019 он, мян.хүн



Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2018-2019 он, сая.төг



Иргэдийн мөнгөн хадгаламж 113.7 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1571.3 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дунджаар 1635.0 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Хадгаламжийн үлдэгдэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20.9 (22.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 08 дугаар сарын эцэст 5.2 тэр бум төгрөг болж, өмнөх сараас 0.8 (1.2%) тэр бум төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 41.2 (16.7%) тэр бум төгрөгөөр өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгллийн 1.8 хувийг эзэлж, өмнөх сараас 0.3 пунктээр өмнөх оны мөн үеэс 0.4

pdfMachine


Is a pdf writer that produces quality PDF files with ease!

Produce quality PDF files in seconds and preserve the integrity of your original documents. Compatible across nearly all Windows platforms, if you can print from a windows application you can use pdfMachine.


Get yours now!

Чанаргүй зээл 08 дугаар сарын эцэст 7162.0 сая төгрөг болж өмнөх сараас 131.3(2.5%) сая төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 1128.8 (13.6%) сая төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.5 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.9 пунктээр буурсан байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2019.08 сард




Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2019.08 сард



2.2 Төсөв, санхүү

2019 оны 08 сарын байдлаар орон нутгийн төсөвт 49482.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 102.3 хувь байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 37.0 хувийг татварын, 14.7 хувийг татварын бус орлого, 48.3 хувийг улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлсэн орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2019 оны 08-р сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 5230.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх оны мөн үеэс 1705.3 (48.4%) сая.төг-өөр, төлөвлөгөөнөөс 2179.7 (71.4%) сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2019 оны 08 дугаар сарыг өмнөх сартай харьцуулахад 0.2 хувь, өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар тус тус өсчээ.

Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 0.2 хувиар өсөхөд: хувцас бөс бараа, гутал 0.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 0.3 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 0.4 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 0.2 хувь, боловсролын үйлчилгээний бүлэг 9.9 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 1.0 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.3 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 10.6 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 5.0 хувь, хувцас бөс бараа, гуталын бүлэг 6.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 1.9 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 3.7 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 4.1 хувь, тээвэрийн бүлэг 2.9 хувь, амралт чөлөөт цаг соёлын барааны бүлэг 4.1 хувь, боловсролын үйлчилгээний бүлэг 9.9 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 9.2 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 6.9 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2019 оны 08 дугаар сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)




Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018-2019 оны үнийн өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)





Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2015-2019 оны 08 дугаар сар (өмнөх оны 12-р сар=100)



Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт




3.1 Хөдөө аж ахуй

Аймгийн хэмжээнд 2018 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 929.6 мянган хээлтэгч малын 678.1 мянга (73.0%) нь 2019 оны эхний 08 сард төллөсөн байна. Эм хонины 80.9 хувь, эм ямааны 71.8 хувь, ингэний 41.1 хувь, үнээний 45.8 хувь, гүүний 41.2 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 99.7 хувь буюу 679.5 мянган төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 87.6 (14.8%) мянгаар нэмэгдсэн байна. Даланжаргалан суманд 72.2 мянга, Дэлгэрэх суманд 70.9 мянга, Айраг суманд 58.3 мянга, Өргөн суманд 53.6 мянга, Алтанширээ суманд 52.8 мянга, Иххэт суманд 52.0 мянга, Хатанбулаг суманд 50.9 мянган төл тус тус бойжсон нь нийт бойжсон төлийн 60.4 хувийг эзэлж байна.

Том малын зүй бус хорогдол 2019 оны эхний 08 сард аймгийн хэмжээнд 4323 болж, өмнөх оны мөн үеэс 4294 (49.8%) толгойгоор буурав. Нийт хорогдсон малын 58.3 хувийг ямаа, 34.9 хувийг хонь эзэлж байна.

Зураг. Том малын зүй бусын хорогдол, жил бүрийн 08-р сард





Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн судалгаагаар Сайншанд суманд 08-р сард ноолуурын дундаж үнэ 70000 төгрөг болж өмнөх онтой адил байна.

Малын зах зээлийн дундаж үнийн мэдээгээр нас гүйцсэн ат Улаанбадрах суманд хамгийн их буюу 1500.0 мянган төгрөг, Иххэт суманд хамгийн бага буюу 800.0 мянган төгрөг, соёолон үрээ Өргөн суманд их буюу 1100.0 мянган төгрөг, Сайхандулаан суманд хамгийн бага буюу 700.0 мянган төгрөг, хязгаалан шар Өргөн суманд хамгийн их буюу 2000.0 мянган төгрөг, Иххэт, Сайхандулаан, Сайншанд, Хөвсгөл, Замын-Үүд сумдад хамгийн бага буюу 1000.0 мянган төгрөг байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Замын-үүд суманд хамгийн их буюу 200.0 мянган төгрөг, Мандах суманд хамгийн бага буюу 120.0 мянган төгрөг, нас гүйцсэн эр ямааны дундаж үнэ Эрдэнэ, Замын-Үүд суманд хамгийн их буюу 150.0 мянган төгрөг, Дэлгэрэх, Мандах, Өргөн сумдад хамгийн бага буюу 100.0 мянган төгрөг байна.



3.2 Аж үйлдвэр

Оны эхний 08 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 130982.6 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 217145.5 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2.4 хувиар буурч, борлуулалт 10.6 хувиар өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 3.4 хувийг төрийн, 96.6 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 3.4 хувь, компани 96.3 хувь, өрхийн аж ахуй 0.3 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан 27.0 мян.ккалаар, ус түгээлт 700.8 мян.м3-аар, сувагжуулалт 527.3 мян.м3-аар, савласан цэвэр ус 178.9 мян.литрээр, талх 13.5 тонноор, нарийн боов 24.4 тонноор, бялуу 0.1 тонноор, хيام 7.9 тонноор, сүүн бүтээгдэхүүн 13.3 мян.литрээр, хэрчсэн гурил 6.9 мян.тн-оор, банш бууз 2.6 тонноор, бетон зуурмаг 5003.8 мян.м3-аар, шохой 11.0 тонноор, цемент 82.7 мян.тонноор, дээл 70 ширхгээр, жижиг оёдол 4303.9 мян.төгрөгөөр тус тус илүү үйлдвэрлэгджээ.

Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



4.1 Байгаль орчин

Цаг уур

08 дугаар сарын дундаж агаарын температур Дэлгэрэх, Айраг, Иххэт, Мандах, Сайхандулаан, Эрдэнэ сумдад 18.2-19.7 градус, бусад сумдын нутгаар 20.1-22.5 градус дулаан, агаарын хамгийн их температур өдөртөө нийт нутгаар 33-37 градус дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж / ОЖД /-тай харьцуулахад: Сайншанд, Өргөн, Эрдэнэ, Айраг, Дэлгэрэх, Сайхандулаан сумдад ОЖД-аас 1.2-2.3 градусаар хүйтэн, бусад сумдад ОЖД-ийн орчим байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө 6-10 градус дулаан, өдөртөө нийт сумдын нутгаар 56-60 градус дулаан байв.

pdfMachine

Is a pdf writer that produces quality PDF files with ease!

Produce quality PDF files in seconds and preserve the integrity of your original documents. Compatible across nearly all Windows platforms, if you can print from a windows application you can use pdfMachine.

Get yours now!



8 дугаар сард нийт нутгаар 4-12 өдөр бороо орж, сарын нийлбэр хамгийн их бороо Иххэт суманд 132.7 мм, хамгийн бага нь Мандах суманд 9.2 мм, Хатанбулаг суманд 15.7 мм орж, бусад сумдын нутгаар 24.8-99.9 мм бороо орлоо. Орсон хур тунадасны нийлбэрийг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Замын-Үүд суманд ОЖД-ийн орчим, Мандах, Хөвсгөл, Хатанбулаг сумдад ОЖД-аас бага, бусад сумдын нутгаар ОЖД-аас ахиу байв.

Энэ сард салхины хамгийн их хурд Сайншанд, Замын-Үүд, Эрдэнэ сумдад секундэд 22-24 метр, Хөвсгөл, Дэлгэрэх сумдад секундэд 17-19 метр хүрч аюултай үзэгдлийн хэмжээнд ажиглагдсан байна. 10 м/с-ээс дээш салхитай 1...14 өдөр байлаа.

Сумын нутгийн 4 зүгийн үнэлгээгээр Сайхандулаан сумын баруун болон өмнө, Улаанбадрах сумын баруунаас бусад хэсгээр ургамлын ургалтын байдал муу, Хөвсгөл сумын баруун болон хойд, Өргөн, Улаанбадрах сумдын баруун, Сайхандулаан сумын зүүн, Хатанбулаг сумын хойд, Мандах сумын нутгаар ургамлын ургалтын байдал дунд, бусад нутагт ургалтын байдал сайн байна. Бэлчээрийн ургамлын дундаж өндөр 6-15 см байна.

_____ о О о _____



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ
(2019 ОНЫ 8 ДУГААР САРЫН БАЙДЛААР)

I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд

	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2019 2018
1. Бэлэн хүн ам, мян.хүн *	МЯНГАН ХВН	66.6	68.2	68.5	70.0	102.2
- Төрсөн хүүхдийн тоо**	тоо	973	830	902	850	94.2
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	243	232	264	254	96.2
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	730	598	638	596	93.4
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	9	6	11	4	5.0 ²
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	9.2	7.2	12.2	4.7	38.6
2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 055	1 705	734	588	80.1
- Үүнээс эмэгтэй	тоо	561	841	337	296	87.8
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	265	402	170	136	79.8
3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	284	302	213	63	29.6
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	148	302	87	45	51.7
Улирлын чанартай ажлын байр	тоо	112	0	126	18	14.3
4. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	1470	532	484	692	143.0
- 10000 хүнд ногдох	тоо	221	78	70	99	142.5
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	452	445	353	392	111.0
- 10000 хүнд ногдох ***	тоо	106	104	82	88	108.0
6.Бойжиж буй төл	толгой	466863	571231	591946	679524	114.8
- Унага	толгой	11609	6342	6512	18663	286.6
- Тугал	толгой	11729	18331	19003	14566	76.7
- Ботго	толгой	5931	13737	15858	6953	43.8
- Хурга	толгой	236137	283809	292632	339672	116.1
- Ишиг	толгой	201457	249012	257941	299670	116.2
6. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	9249.1	89580.5	134240.4	130982.6	97.6
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	6242.1	145349.5	196299.4	217145.5	110.6

* - 2016,2017,2018 оны жилийн эцэст

** - Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.

pdfMachine

Is a pdf writer that produces quality PDF files with ease!

Produce quality PDF files in seconds and preserve the integrity of your original documents. Compatible across nearly all Windows platforms, if you can print from a windows application you can use pdfMachine.

Get yours now!



НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

	Хэмжих нэгж	2018 I-VIII	2019 I-VIII	Өсөлт	
		тоо		хувь	
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	233.5	261.6	28.1	112.0
2. Ор хоног	мян.хүн	81.5	80.6	-0.9	98.9
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	7.5	7.3	-0.2	97.3
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	11.4	11.3	-0.1	99.1
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	13.3	13.3	0	100.0
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	2.3	2.1	-0.2	91.3
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	2177	2149	-28	98.7
Үүнээс: нас баралт	хүн	68	53	-15	77.9
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	1072	1250	178	116.6
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	943	1102	159	116.9
8. Амаржсан эх	хүн	899	847	-52	94.2
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	3	2	-1	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	11	4	-7	

1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн 08 сард

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
	тоо				
Дүн	847	0	850	4	2
Айраг					1
Алтанширээ					
Даланжаргалан	1		1		
Дэлгэрэх					
Иххэт					
Мандах					
Өргөн	1		1		
Сайхандулаан	1				
Улаанбадрах					
Хатанбулаг	2		2		
Хөвсгөл	2		2		
Эрдэнэ	2		2		
Сайншанд	672		676	4	1
Замын - Үүд	166		166		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн 08 сард

Үзүүлэлт	2018 I-VIII	2019 I-VIII	Өсөлт	
	Тоо	Тоо	Тоо	Хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	484	692	208	143.0
Вируст гепатит	5	5	0	100.0
Сүрьеэ	68	61	-7	89.7
Тэмбүү	75	126	51	168.0
Заг хүйтэн	130	191	61	146.9
Трихоминиаз	61	117	56	191.8
Цусан суулга	51	29	-22	56.9
Бусад	94	163	69	173.4

Тайлбар -²-дахин их

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар

pdfMachine**Is a pdf writer that produces quality PDF files with ease!**

Produce quality PDF files in seconds and preserve the integrity of your original documents. Compatible across nearly all Windows platforms, if you can print from a windows application you can use pdfMachine.

Get yours now!



ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 08 сард

Боловсролын түвшингээр	2016 VIII	2017 VIII	2018 VIII	2019 VIII	2019 VIII 2016 VIII	2019 VIII 2018 VIII
	хүний тоо				хувь	
ДҮН	1 055	1 705	734	588	55.7	80.1
Үүнээс: Эмэгтэй	561	841	337	296	52.8	87.8
Магистр, доктор	11	8	0	3	27.3	0.0
Дээд боловсролтой	277	388	114	69	24.9	60.5
Тусгай дунд	115	159	25	18	15.7	72.0
Техник мэргэжлийн	116	158	45	21	18.1	46.7
Бүрэн дунд	376	781	486	420	111.7	86.4
Бүрэн бус дунд	125	165	40	37	29.6	92.5
Бага	26	23	7	3	11.5	42.9
Боловсролгүй	9	23	17	17	188.9	100.0

2.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 08 сард

	Ажилгүй иргэдийн тоо		Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн хүний тоо	
	2018 VIII	2019 VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII
ДҮН	734	588	314	313	1642	29
Айраг	57	5	29	2	128	2
Алтанширээ	12	3	9	13	65	0
Даланжаргалан	18	26	22	34	63	0
Дэлгэрэх	12	8	4	5	17	0
Иххэт	33	10	18	5	81	0
Мандах	15	6	55	5	89	0
Өргөн	14	7	22	72	58	0
Сайхандулаан	10	2	4	7	26	1
Улаанбадрах	15	7	36	12	71	0
Хатанбулаг	10	9	8	16	52	0
Хөвсгөл	2	5	12	5	23	0
Эрдэнэ	32	38	4	20	48	2
Сайншанд	356	344	71	58	671	15
Замын - Үүд	148	118	20	59	250	9

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, 2019 оны 08 сарын эцэст

Салбарын ангилал	2018 I-VIII	2019 I-VIII
	Тоо	
Бүгд	415	336
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	10	24
Уул уурхай олборлох аж үйлдвэр	157	126
Боловсруулах үйлдвэрлэл	5	1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	4	2
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын	7	12
Барилга	48	23
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар	1	
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	16	4
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1	2
Мэдээлэл, холбоо		
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	13	6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа		
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа		
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	2	
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан	48	30
Боловсрол	15	20
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	25	7
Урлаг, үзвэр,тоглоом наадам	9	1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	53	78
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн		
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1	

2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, 2019 оны 08 сарын эцэст

Үзүүлэлт	2018 I-VIII	2019 I-VIII
	Тоо	
Бүгд	415	336
Менежер	3	7
Мэргэжилтэн	92	39
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	44	51
Контор, үйлчилгээний ажилтан	14	22
Худалдаа, үйлчилгээний ажилтан	33	17
ХАА, ой загас агнуурын ажилтан	3	15
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	24	22
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	69	39
Энгийн ажил мэргэжил	123	118
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	10	6

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангиллаар жил бүрийн 08 сард

Үзүүлэлт	2018 I-VIII		2019 I-VIII	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	тоо		тоо	
Бүгд	314	121	313	128
Менежер	3	2	5	4
Мэргэжилтэн	49	32	37	27
Техникч болон туслах дэд/мэргэжилтэн	29	17	48	20
Контор, үйлчилгээний ажилтан	16	10	20	18
Худалдаа, үйлчилгээний ажилтан	28	18	13	11
ХАА, ой загас агнуурын ажилтан	1		15	5
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил	16	3	21	3
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	51	10	38	1
Энгийн ажил мэргэжил	112	25	111	35
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	9	4	5	4

2.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 2019 оны 08 сард

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар	
			Байнга	Улирал
	тоо			
Бүгд	63	23	45	18
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	23		6	17
Уул уурхай олборлолт	1		1	
Боловсруулах үйлдвэрлэл	1	1	1	
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж				
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент				
Барилга	1		1	
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	2		2	
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	3	2	3	
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	1	1	1	
Мэдээлэл холбоо				
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1	1	1	
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл	25	16	24	1
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа				
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	3	1	3	
Боловсрол	2	1	2	
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа				
Урлаг үзвэр тоглоом наадам				
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа				
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа				
Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар				



ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 08 сард

Үзүүлэлт	2018 I-VIII	2019 I-VIII	2019 I-VIII 2018 I-VIII
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	21 100.2	27 452.8	130.1
Тэтгэврийн даатгалын сан	13 275.7	17 337.9	130.6
Тэтгэмжийн даатгалын сан	1 504.6	1 965.0	130.6
Эрүүл мэндийн даатгалын сан	3 512.1	4 486.5	127.7
ҮОМШӨ*-ний даатгалын сан	2 198.7	2 869.6	130.5
Ажилгүйдлийн даатгалын сан	609.1	793.8	130.3
Нийгмийн даатгалын сангийн зарлага	29 416.8	33 449.2	113.7
Тэтгэврийн даатгалын сан	21 428.7	24 789.7	115.7
Тэтгэмжийн даатгалын сан	1 686.6	1 930.0	114.4
Эрүүл мэндийн даатгалын сан	4 030.2	4 017.8	99.7
ҮОМШӨ*-ний даатгалын сан	1 642.9	2 014.1	122.6
Ажилгүйдлийн даатгалын сан	628.4	697.6	111.0

3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 08 сард

Үзүүлэлт	2018 I-VIII	2019 I-VIII	2019 I-VIII 2018 I-VIII
	хүн		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	20301	20874	102.8
Албан журмаар даатгуулагчид	16578	17062	102.9
Аж ахуй нэгж, байгууллага	8460	8892	105.1
Төсөвт байгууллага	8118	8170	100.6
Сайн дураар даатгуулагчид	3723	3812	102.4
2. Тэтгэвэр авагчдын тоо	8188	8611	105.2
Өндөр насны тэтгэвэр	5866	6205	105.8
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1219	1294	106.2
Тэжээгчээ алдсаны	523	504	96.4
Цэргийн тэтгэвэр	423	456	107.8
ҮОМШӨ*-ний	157	152	96.8
	сая төгрөг		
3. Олгосон тэтгэвэр	21 971.7	25 263.0	115.0
Өндөр насны тэтгэвэр	15 966.5	18 290.6	114.6
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	2 477.0	2 927.8	118.2
Тэжээгчээ алдсаны	1 092.2	1 185.2	108.5
Цэргийн тэтгэвэр	1 856.0	2 282.2	123.0
ҮОМШӨ*-ний	580.0	577.2	99.5

Тайлбар: *-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс



3.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сумаар

Сумын нэр	2018 I-VIII	2019 I-VIII	2019 I-VIII 2018 I-VIII
	сая төгрөг		хувь
ДҮН	21100.2	27452.8	130.1
Айраг	366.3	476.6	130.1
Алтанширээ	125.0	164.5	131.6
Даланжаргалан	986.2	1201.4	121.8
Дэлгэрэх	152.4	198.3	130.1
Иххэт	199.2	355.3	178.4
Мандах	237.2	221.3	93.3
Өргөн	605.9	986.2	162.8
Сайхандулаан	162.9	224.7	137.9
Улаанбадрах	161.2	210.1	130.3
Хатанбулаг	371.7	464.1	124.9
Хөвсгөл	164.2	208.9	127.2
Эрдэнэ	294.8	387.2	131.3
Сайншанд	11915.8	15308.1	128.5
Зүүнбаян баг	624.3	794.1	127.2
Замын-Үүд	4733.1	6252.0	132.1

3.4 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сумаар

Сумын нэр	2018 I-VIII	2019 I-VIII	2019 I-VIII 2018 I-VIII
	сая төгрөг		хувь
ДҮН	29416.8	33449.2	113.7
Айраг	1478.2	1652.5	111.8
Алтанширээ	571.4	624.3	109.3
Даланжаргалан	1133.7	1504.1	132.7
Дэлгэрэх	518.6	691.0	133.2
Иххэт	1072.7	1195.7	111.5
Мандах	655.4	693.5	105.8
Өргөн	1109.8	1294.0	116.6
Сайхандулаан	425.5	464.8	109.2
Улаанбадрах	645.3	748.1	115.9
Хатанбулаг	1131.8	1300.0	114.9
Хөвсгөл	556.4	613.1	110.2
Эрдэнэ	976.8	1118.3	114.5
Сайншанд	12542.0	13887.9	110.7
Зүүнбаян баг	1136.2	1228.6	108.1
Замын-Үүд	5463.0	6433.3	117.8



3.5 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 08 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2019 I-VIII 2018 I-VIII	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2019 I-VIII 2018 I-VIII
	2018 I-VIII	2019 I-VIII		2018 I-VIII	2019 I-VIII	
	тоо		хувь	сая төгрөг	хувь	
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ	22506	23425	104.1	5378.8	5578.6	103.7
1. Халамжийн тэтгэвэр	1353	1374	101.6	1511.4	1701.1	112.6
Ахмад настны тэтгэвэр	59	78	132.2	64.6	92.1	142.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	1294	1296	100.2	1446.8	1609.0	111.2
2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж	1067	1046	98.0	505.9	548.9	108.5
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэнд олгосон тэтгэмж	1004	987	98.3	473.7	515.3	20.5
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжих байгаа иргэнд олгох тэтгэмж	51	50	98.0	26.9	28.5	105.9
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	6	7	116.7	3.1	3.9	125.8
Ахмад настныг гэртээ асрамжилж байгаа иргэн	5	2	40.0	1.6	1.2	75.0
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн	1			0.6	0.0	0.0
3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн	993	936	94.3	399.5	384.5	96.2
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	234	225	96.2	256.1	270.1	105.5
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	711	678	95.4	82.2	72.8	88.6
Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/	4			0.4	0.0	
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	10	7	70.0	20.0	14.0	70.0



Үзүүлэлт	Хүснэгт 3.5-ийн үргэлжлэл					
	Хамрагдсан хүний тоо		2019 I-VIII 2018 I-VIII	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2019 I-VIII 2018 I-VIII
	2018 I-VIII	2019 I-VIII		2018 I-VIII	2019 I-VIII	
	тоо		хувь	мянган төгрөг		хувь
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	11	5	45.5	13.2	6.0	45.5
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	11	17	154.5	13.2	20.4	154.5
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	12	1	8.3	14.4	1.2	8.3
Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, 4 ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон иргэн		3			3.6	
4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал	0	0		0	0	
